



Khan of 1 mile Mongolia ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Багийн бүрэлдхүүн. Энэ бол багийн тэмцээн. Баг нь 2 хүртэл хүний бүрэлдхүүнтэй байх бөгөөд буудагч болон споттер (чиглүүлэгч) нараас бүрдэнэ. Тэмцээний явцад нэг удаа хүндэтгэх шалтгааны улмаас споттерийг сольж болно. Үүнийг тэмцээний ерөнхий шүүгч шийднэ.

1.2 Нэг споттер нь зөвхөн нэг буудагчтай баг байна.

1.3 Споттер нь буудагч байх буудагч нь споттер байж болохгүй.

1.4 Буудах дарааллыг зөвхөн сугалаагаар тогтоно.

1.5 Буудагчийн нэр, споттерийн нэр, зэвсэгийн мэдээллийг тэмцээн болохоос нэгээс багагүй хоногийн өмнө зохион байгуулагчид мэдэгдэнэ.

1.6 Тэмцээнд хоёр буудагч дундаа нэг зэвсэгтэй оролцож болно. Хэрвээ финалийн шатны тэмцээнтэй үед нэг зэвсэгээр оролцож байгаа буудагчид финалд шалгарсан тохиолдолд зөвхөн аль нэг буудагч нь тухайн зэвсэгээр үргэлжлүүлэн оролцоно. Нөгөө буудагч хасагдана.

1.7 Байны байрлал, зай, өнцөг, буудах тоо зэрэг мэдээллийг тэмцээний урд өдрийн орой тэмцээний ерөнхий шүүгч нийт багуудад мэдэгдэнэ.

1.8 Зэвсэгт тавигдах шалгуур: 338 калибр болон түүний доошоо бүх төрлийн калибртай зэвсэгийн нийт жин 26 паунд буюу 11,79кг-аас ихгүй байна. Зэвсэгийн жин гэдэгт тухайн зэвсэгийн буудлага үйлдлэх үед угсрагдсан байх бүх тоног төхөөрөмжийг (Зэвсэгт нэмэлтээр угсардаг урд болон хойд хөл, тулгуур жинтүүнээс бусад) оруулж тооцно. Зэвсэгт хуулиар хориглосноос бусад дараах нэмэлт тоноглолыг зөвшөөрнө. Үүнд: Тийрэлт бууруулагч, дөл баригч, нэмэлт рейл, саланги болон үргэлж дурангийн бөгж, дуран (шөнийн хараалах хэрэгсэл, дулаан мэдрэгчээс бусад), тэгш ус, өнцөг хэмжигч, сум тогтоогч (2 ширхэг сумаас ихгүй), дурангийн таг, гялбааны хамгаалалт орно.

1.9 Хэрэв зэвсэгийн жин 11,79 кг их байвал илүү гарсан бүрэн бус 1/10 паунд буюу 0,045кг тутамд (-1000) онооны торгуул оногдоно. Жишээ нь: 11,84 кг жинтэй бол -1000 оноо, 11,85кг байвал (-2000) оногдуулах гэх мэт тооцно. Энэхүү торгуулийн оноо нь тэмцээний эцсийн дүнгээс хасагдаж тооцно.

1.10 Зэвсэгийн урд хөл: Зэвсэгийн урд талд бэхэлдэг, түргэн авагддаг рейл, суурь эсвэл Ext буюу урд хөл уртасгагч зэргээр буудлага үйлдэх үед зэвсэгт хэрэглэдэг нэмэлт тоноглолыг ойлгоно. Зэвсэгийн урд хөл нь сундаг, зэвсэгийн гол төмрийн дагуу урагш болон хойш эвхэгддэг байна. Мөн зэвсэгийн гол төмрийн дагуу эвхэгдсэн байх үедээ өргөн нь (мөр хоорондын) 8 инч буюу 20,3см өргөнгүй байна. Зэвсэгийн хөл нь босоо байрлалд механикаар сундаг байна. Зэвсэгийн хөл нь зэвсэгт нэг үйлдлээр бэхлэгддэг байна. Мөн урд хөлийг

сунгах, эвхэх үйлдэл нь ямар нэг тусгай багаж хэрэгсэл, төхөөрөмж ашиглаж хийдэггүй, буудах байрлал дээрээс буудагч шууд уртасгах, эвхэх, сунгах үйлдэлийг 10 секундад багтааж хийх боломжтой байна. Зэвсэгийн урд хөл нь дээрээ зэвсэгээс өөр аливаа нэмэлт тоног төхөөрөмж байрлуулах боломжгүй байна.

Зэвсэгийн урд хөлний газартай харилцах хэсэг нь дэвсгэр цоолох, зүсэх хэмжээний иртэй эсвэл үзүүртэй байж болохгүй.

1.11 Буудагч нь тэмцээний үед зэвсэгтэй харилцах, тохируулга хийх бүх үүргийг өөрөө гүйцэтгэнэ. Жишээлбэл: зэвсэг, рейл, дуран, зэвсэгийн хөлний тохиргоо хийх, жинг тааруулах, зэвсэг цэнэглэх, аюулгүй болгох гэх мэт.

1.12 Гал нээсэн үед буудагч нь зэвсэгийн аливаа нэмэлт тоног төхөөрөмж, сум хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл (сонсгол хамгаалах, нүд хамгаалах) болон бусад тэмдэглэл зэрэг эд зүйлсийг мартсан бол зэвсэгийг аюулгүй болгосны дараа шүүгчээс зөвшөөрөл авсаны дараа галын шугамнаас гарч авч ирнэ. Энэ үйлдэлийг зөвхөн буудагч өөрөө гүйцэтгэнэ.

1.13 Зэвсэгийн хойд тулгуур/жинтүү нь ямарч хэлбэр хийцтэй байхыг зөвшөөрнө. Зэвсэгийн хойд тулгуур нь зэвсэгт нэмэлтээр бэхэлсэн байж болно эсвэл зэвсэгийн хийцтэй холбоотой ирсэн байж болно. Аль ч тохиолдолд урт богиныг тохируулдаг, эвхэж хураадаг тохиргоотой байж болно.

1.14 Сум хэрэгсэл, дэвсгэр, тэмдэглэл зэрэг бусад хувийн хэрэглээний эд зүйлсийг галт зэвсэгтэй хамт нэг удаа зөөж явж чадахуйц байна. Гэхдээ буудагч нь 65 болон түүнээс өндөр настай, эсвэл тулгуур эрхтэний хөгжлийн бэрхшээлтэй иргэн байвал уг нөхцөл хамаарахгүй.

1.15 Гал нээх зурваст дэвсгэр байрлуусан байна.

1.16 Зэвсэг болон зэвсэгийн дуран, споттерийн дуран хэрэгсэл нь түгээмэл, нийтэд худалдаалдаг, хязгаарлагдмал хүрээний бус хэрэгсэл байна. Ямар ч баг гал нээх зурвас болон зурвасын гадна байны камер, дрон буюу удирдлагатай нисдэг төхөөрөмж, дуу ялгах (i.e. Doppler Radar) төхөөрөмж зэргийг ашиглахыг хориглоно. Мөн сонсгол хамгаалах хэрэгсэлд радио, нам болон өндрийн станц ашиглах, сонсох ярих үйлдлийг хориглоно.

1.17 Тэмцээний явцад баг нь бүх төрлийн тоног төхөөрөмжийг ашиглахыг хориглоно. Үүнд салхины хурд, чиг, агаарын чийгшил болон бусад хүрээлэн буй орчины мэдээлэл цуглуулагч төхөөрөмж багтана.

1.18 Галын зурваст байх бүх хүн сонсгол болон нүд хамгаалах хэрэгсэл зүүсэн байна. Зарим тохиолдолд споттерийн дуран нь хамгаалах хэрэгсэлтэй хараалах үед хүндрэлтэй бол зөвхөн буудагчийн ард байрласан тохиолдолд шүүгчийн зөвшөөрлөөр нүд хамгаалах хэрэгсэлийг тайлж болно.

1.19 Зэвсэг/тоног төхөөрөмжинд гэмтэл үүсэх: Гал нээх команд өгсөний дараа зэвсэг болон бусад нэмэлт тоног төхөөрөмжинд гэмтэл, гацалт үүссэн үед цаг зогсохгүй. Буудагч үүссэн гэмтэл, асуудлыг ганцаараа шийднэ, хэрвээ хөндлөнгийн этгээдийн тусламж хэрэгтэй бол талбайн шүүгч зөвшөөрсөний үндсэн дээр тусламж авч болно. Хэрэв буудагч үүссэн нөхцөл байдалтай холбоотой тэмцээнийг үргэлжлүүлэх боломжгүй бол зэвсэгийг аюулгүй болгосны дараа шүүгчийн зөвшөөрлөөр галын зурвасыг чөлөөлнө.

1.20 Ямар ч үед буудагч нь зэвсэгийн амыг буудах байны зүг, эсвэл дээш чиглүүлсэн байна, мөн буудалт хийхээс бусад үед гохон дээр хуруу тавихгүй. Хэрэв зөрчсөн бол шууд DQ/хасагдах торгууль оногдуулна. DQ/хасагдах торгууль оногдуулсан багийн гишүүд тухайн тэмцээнээс шууд хасагдана.

1.21 Тэмцээний явцад байны камер эвдэрсэн, байнд гэмтэл үүссэн бол тэмцээний ерөнхий шүүгч гал зогсоож, тухайн дасгалын оноог тэглэнэ. Зэвсэг аюулгүй болсоны дараа гэмтэлийг сэргээх ажил зохион байгуулна. Багийн хувьд тухайн буудалт үргэлжилж байсан байн дээр 1 сум буудаж (Оноонд тооцогдохгүй), үүний дараа тэмцээнийг зогссон хугацаанаас эхлэн үргэлжлүүлнэ. Тэмцээний ерөнхий шүүгчийн шийдвэр эцсийнх байна.

1.22 Тэмцээний үед хөгжөөн дэмжигч байхыг хориглоно. Энэ нь оноо цуглуулж байгаа багийн хувьд гадны нөлөө үзүүлэх магадлалтай.

1.23 Тэмцээн галын зурвас хэсэг явагдана. Буудагч болон споттер нь галын зурваст байрлалаа өөрснөө сонгоно. Хөгжөөн дэмжигч нь галын зурвасаас хангалттай хол зайд тэмцээний зохион байгуулагчидийн бэлдсэн хэсэгт шууд дамжуулах дэлгэцээр тэмцээнийг үзнэ.

1.24 Тэмцээний үед зөвхөн байг оносон бол шүүгч оносон гэж чанга дуугаар мэдэгдэнэ.

1.25 Шүүгч байг дуран, шууд дамжуулах дэлгэцийн аль нэг хэлбэрээр хянаж оносон эсэхийг хэлэх бөгөөд бай нь оносон эсэх нь тодорхойгүй нөхцөлд байны зүгээс ирэх метал биетийн чимээгээр оносон эсэхийг тогтоох боломжгүй. Энэ нөхцөлд бичлэг ухрааж үзэж болно. Ямар ч нөхцөлд бичлэг ухрааж харах нь зөвхөн ерөнхий шүүгчийн зөвшөөрлөөр хийгдэнэ.

1.26 Хэрэв буудагч эсвэл споттер нь шүүгчийн шүүлттэй санал нийлэхгүй бол ерөнхий шүүгчид саналаа тавьж болно. Энэ нөхцөлд 50 000 төгрөгийн баталгаа байршуулна. Хэрэв бичлэг харах явцад гомдол гаргагч ялсан бол 50 000 төгрөгийг буцааж өгнө. Хэрэв шүүлт зөв явагдсан бол 50 000 төгрөг буцаагдахгүй. Урьдчилж баталгаа гаргасан нөхцөлд тэмцээний дараа бичлэгийг хамтран шалгаж нийтэд мэдэгдэнэ.

1.27 Баг буудалт дууссаны дараа түргэн хугацаанд зэвсэг болон бусад тоног төхөөрөмжийг хурааж дараагийн багт бэлтгэх боломжийг олгоно. Зэвсэгийг авч ирэх, явах, бэлтгэх үед магазин салгаатай, замаг нээлттэй, аюулгүйн дарцагыг гол төмөрт харагдахуйц оруулсан байна. Бэлтгэх хугацаанд хуурай буудалт хийж болохгүй.

1.28 Баг нь зөвхөн өөрийн буудах ээлж ирсэн үед байны зүг зэвсэгийн болон споттерийн дуранг ашиглаж харна. Бусад үед аливаа дуран хэрэгсэл ашиглаж харахыг хориглоно.

1.29 Ерөнхий шүүгч нийт баг, оролцогсдод хандан тэмцээний бай, байны хэмжээ, чиглэл, зай, өнцөг болон буудах сумны тоо, зарим тохиолдолд салхи болон өндөржилт, орчины мэдээлэл, буудах газрын мэдээлэл зэргийг өгч болно.

ХОЁР. ОРОЛЦОГСДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1 Баг нь газрын зураг, байны байршил, буудах зай болон GPS, зай хэмжигч зэрэг өөрийн туслах тоног төхөөрөмжүүдийг бэлтгэж авч явна.

2.2 Баг тус бүр өөрсдийн гал нээх дараалал, цагийг мэдэж байна. Хэрэв бэлэн биш байсанаас үүдэлтэй бэлтгэх хугацаа хоцорвол тэмцээний ерөнхий шүүгч шууд DQ/тэмцээнээс хасах торгууль оногдуулна.

ГУРАВ. ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

3.1 Байны зай 1000 метрээс 1609,3 метр байна. Баг 5 минут бэлтгэл хангаж, 9 минут дотор багтаан нийт 4 өөр зайнд байрлах металл байг 13 сумаар буудаж гүйцэтгэнэ.

3.2 Эхний байнд “хүйтэн гол төмрийн нөлөө”-ний нэг буудалт хийнэ. Энэхүү буудалтанд оноо тооцогдохгүй.

3.3 Нийт 3 бай тус бүрт 4 сум тус бүр буудалт хийх бөгөөд нийт оноонд тооцогдох 12 сум байна.

3.4 Буудагч бай тус бүрт буудах сумны тоог бүрэн гүйцэтгэсний дараа дараагийн байруу шилжинэ. Хэрэв дасгалыг бүрэн дуусгалгүй дараагийн байруу шилжсэн бол тэмцээнээс хасагдана.

3.5 Тэмцээний 2 дахь үе буюу эцэсийн шалгаруулалтанд оролцогч 5 баг тутамас нэг баг шалгаруулж оролцуулах бөгөөд 10 ба түүнээс дээш баг оролцоогүй тохиолдолд эцэсийн шалгаруулалт буюу 2 дахь үе гарахгүй.

3.6 Эхний байнд “хүйтэн гол төмрийн нөлөө”-ний нэг буудалт хийнэ. Энэхүү буудалтанд оноо тооцогдохгүй.

3.7 Нийт 2 бай тус бүрт 3 сум тус бүр буудалт хийх бөгөөд нийт оноонд тооцогдох 6 сум байна.

3.8 Эцсийн шалгаруулалтад дасгалыг хүндрүүлэх зорилгоор байнуудыг зайг холдуулж байршуулна. Жишээ нь: Үндсэн тэмцээнд 1000~1199м байршуулсан байг 1200~1399м хооронд байршуулах гэх мэтээр.

3.9 Нийт буудалтын тоо 20. Оноонд тооцогдох 18 буудалт байна.

ДӨРӨВ. БАЙНЫ ХЭМЖЭЭ БА ЗАЙ

4.1 Үндсэн тэмцээний бай нь;

-1000~1199м зайнд 43,6см*58,9см.

-1200~1399м зайнд 52,5см*70,7см

-1400~1609м зайнд 61,1см*82,5см байх бөгөөд тэмцээний өглөө аль байг хэдэн метр зайнд байршуулахыг 20м алгасалттай сугалаа ашиглан шийдвэрлэнэ. 1000м зайнд “Хүйтэн гол төмрийн нөлөө” шалгах бай байршуулна.

1100-1200м 1300-1400м 1500-1600м зайнд үндсэн тэмцээний байг байршуулах бөгөөд сугалаагаар сугалж шийдвэрлэнэ. Жишээ нь 1100~1200 метрийн зайнд 1120,1140,1160 гэх мэт тэмдэгэлгээтэй 5ш сугалаа байна.

ТАВ. ОНОО ДҮГНЭХ

5.1 Оноог дүгнэхдээ эхний онолтоор оносон бол хамгийн өндөр оноо өгнө, ийнхүү тухайн байнд оносон онолт бүрээр буурах дарааллаар ялгаатай үнэлнэ. Тухайлбал: Байнд 4 буудалт хийх ба эхний буудалтаар оносон бол 5 оноо, хоёр дах буудалтаар оносон бол 4 оноо, гуравдах буудалтаар оносон бол 3 оноо, дөрөв дэх буудалтаар оносон 2 оноо гэж үнэлнэ. Буудагч 2 болон 4 дэх буудалтаар байг оносон бол $5+2=7$ оноо цуглуулсан гэсэн үг.

5.2 Мөн байны зайн нь оноог ялгаатай үнэлэх нэг шалгуур болно. Тухайлбал: Буудалт хийж цуглуулсан оноог тухайн буудалт хийсэн байны зайнд үржүүлж тооцно. 1560 метр зайнд буудсан бол буудагчийн цуглуулсан 7 оноо*1560=10920 оноо цуглуулсан байна.

5.3 Цаг ашиглалт оноонд шууд нөлөө үзүүлж чадахгүй ч тодорхой хэмжээнд бонус оноо болон бодогддог. Буудалтын хугацаа 9 минут байх бөгөөд энэ нь 540 секунд юм. Буудагч 7 минут 16 секунд (436 секунд) хугацаанд буудалтаа дуусгасан бол үлдэх хугацаа нь $540-436=104$ секунд буюу 104 онооны бонус болгон нэмж авна.

5.4 Зэвсэгийн үзлэгийн үеэр буудагч нь торгуулийн оноо буюу хасагдах оноотой бол тухайн багийн нийт онооноос уг оноог хасаж нийт оноог тооцно.